

**ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС
ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА:

Аудитын нэр:	3
Аудитын код:	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	3
Аудитын зорилго:	3
Аудитын хамрах хүрээ:	3
Ерөнхий мэдээлэл:	3
Эрсдэлийн үнэлгээ:	5
Аудитын арга зүй:	5
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:	5
Аудит хийх багийн бүрэлдэхүүн:	7
Аудит хийх хугацаа:	7
Аудитын хөтөлбөр:	8
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:	8
Аудитад шаардагдах нөөц:	8

Хавсралт №1 Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ

Хавсралт №2 Асуудлын шинжилгээ

Хавсралт №3 Аудитын загварын матриц

Хавсралт №4 Аудитын хөтөлбөр

Хавсралт №5 Шинжээчийн ажлын даалгавар

Товчилсон үгийн жагсаалт:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ААНБ	Аж, ахуй нэгж байгууллага
УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

БАТЛАВ.

Д.ЗАНДАНБАТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын нэр: Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

Аудитын код: АГГ-2021/12-ШТА-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, МҮЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилго:

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.

Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй төрийн тусгай болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллагууд, төр, хувийн өмчийн лабораториуд, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч хуулийн этгээд, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулна.

Ерөнхий мэдээлэл:

Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Органик хүнсний тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", УИХ болон ЗГ-ын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөрүүд, тогтоол, журмууд, хүнсний аюулгүй байдалтай холбоотой стандартууд болон бусад хууль, эрх зүйн актуудаар хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Монгол Улс хүнсний хэрэгцээг дотоодод үйлдвэрлэх болон импортлох хэлбэрээр бүрдүүлж байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 1 харуулав)

Хүснэгт 1. Хүнсний хангамжийн мэдээлэл, хувиар

Д/д	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2018 он		2019 он	
		Дотоодын үйлдвэрлэл	Импорт	Дотоодын үйлдвэрлэл	Импорт
1	Мах, махан бүтээгдэхүүн	96.7	3.3	96.3	3.7
2	Сүү	100	0.0	100	0.0
3	Сүүн бүтээгдэхүүн	65.8	34.2	69.3	30.7
4	Гурил, гурилан бүтээгдэхүүн	90.7	9.3	88.3	11.7
5	Төрөл бүрийн будаа	0.0	100	0.0	100
6	Төмс	98.3	1.7	99.8	0.2
7	Хүнсний ногоо	53.5	46.5	56.0	44.0
8	Буурцагт ургамал	93.5	6.5	87.1	12.9
9	Жимс, жимсгэнэ	3.3	96.7	3.3	96.7
10	Өндөг	50.4	49.6	52.6	47.4
11	Ургамлын тос	1.7	98.3	2.0	98.0
12	Цөцгийн тос, 72 хувийн тослогтой	30.2	69.8	47.0	53.0
13	Сахар, чихрийн зүйл	58.1	41.9	63.7	36.3

Эх сурвалж: УСХ

Хүнсний хангамжийн 2019 оны түвшинг өмнөх онтой харьцуулбал мах, махан бүтээгдэхүүн 9.0 пункт, төмс 18.0 пункт, сүүн бүтээгдэхүүн 21.5 пункт, сүү 95.6 пункт, өндөг 9.9 пункт, жимс жимсгэнэ 1.6 пунктээр тус тус өссөн бол ургамлын тос 4.5 пункт, цөцгийн тос 0.5 пункт, сахар, чихрийн зүйл 32.9 пункт, төрөл бүрийн будаа 5.9 пункт, гурил, гурилан бүтээгдэхүүн 10.4 пункт, хүнсний ногоо 4.4 пунктээр буурч, буурцагт ургамлын хангамжийн түвшин өөрчлөгдөөгүй байна.

Монгол Улсын хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2019 оны байдлаар Үндэсний статистикийн хорооноос хийсэн тооцооллоор жилд 179.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 150.9 мянган тонн сүү, 169.7 мянган тонн сүүн бүтээгдэхүүн, 94.3 мянган тонн гурил, 169.7 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 47.1 мянган тонн будаа, 31.1 мянган тонн сахар, чихрийн зүйл, 113.2 мянган тонн төмс, 245.2 мянган тонн хүнсний ногоо, 37.7 мянган тонн буурцагт ургамал, 188.6 мянган тонн жимс, жимсгэнэ, 18.9 мянган тонн өндөг, 21.7 мянган тонн ургамлын тос, 9.4 мянган тонн цөцгийн тос байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар жишсэн нэг хүний улсын дундаж хүнсний бодит хэрэглээг авч үзэхэд хөдөө, орон нутагт сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, мах, махан бүтээгдэхүүн, ургамлын тос, будааг улсын дунджаас давж хэрэглэдэг бол нийслэлд гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, төмс, өндөг, жимс, жимсгэнэ, цөцгийн тос, сахар, чихрийн зүйл, буурцагт ургамлыг улсын дунджаас давж хэрэглэж байна.

Хүнсний хүртээмж өрхийн түвшинд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, төмс, сахар, чихрийн зүйлийн хүртээмж хангалттай, бусад хүнсний бүтээгдэхүүний хүртээмж хангалтгүй буюу дутагдалтай байна.

Зуны улиралд: Улсын дунджаар жишсэн нэг хүний хүнсний бүтээгдэхүүнээс авсан илчлэг 3065.3 килокалори, уураг 136.7 грамм, тос 72.3 грамм, нүүрс ус 468.9 грамм байгаа нь хүнснээс авах илчлэгийн нормтой харьцуулахад 8.0-51.9 хувиар өндөр байна.

Сэрүүний улиралд: Улсын дунджаар жишсэн нэг хүний хүнсний бүтээгдэхүүнээс авсан илчлэг 2930.3 килокалори, уураг 131.5 грамм, тос 66.4 3 грамм, нүүрс ус 453.4 грамм байгаа нь хүнснээс авах илчлэгийн нормтой харьцуулахад илчлэг, нүүрс ус, уургийн хэмжээ нормоос 22.1- 46.1 хувиар их, тосны хэрэглээ 0.9 хувиар бага байна.

Хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн 69 лаборатори 2019 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байна. МХЕГ-ын Хяналтын итгэмжлэгдсэн лаборатори нэгдсэн сүлжээний хэмжээгээр хими хор судлал, эрүүл ахуй нян судлал, ургамал хорио цээрийн чиглэлээр 106.1 мянган сорьцод 290.6 мянган үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 3.5 мянган сорьц стандартын шаардлага хангаагүй, бохирдлын түвшин 3.3% гарсан байна.

Монгол Улсын хэмжээнд хүнсний холбогдолтой үндэсний 668 стандартыг мөрдөж байгаагаас 264 буюу 39.5 хувь нь олон улсын стандартын түвшинд нийцсэн, 404 буюу 60.5 хувь нь уялдуулан боловсруулагдсан байна.

Монгол Улсад чанарын удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг хангаж, гэрчилгээ олгогдсон, Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2010 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хүнсний салбарын 19 ААНБ байна.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн. *(Хавсралт 1)*

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглана.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх бөгөөд төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй нь аудитын бүх үе шатны туршид үргэлжлэх үйл ажиллагааг хамрах тул аудитын явцад томоохон өөрчлөлт гарсан тохиолдолд гүйцэтгэл, тайлагналын үе шатанд нэмэлт горим хэрэгжүүлэх шийдвэрт хүрвэл төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно.

Мөн аудитад хүнсний салбарын бодлого, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, уялдаа холбоо болон салбарт мөрдөгдөж буй хууль, стандартын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийг татан оролцуулна. *(Хавсралт 2, Хавсралт 3)*

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

Хууль:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль;
- Органик хүнсний тухай хууль;
- Баяжуулсан хүнсний тухай хууль;
- Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль;
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль;

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл ахуйн тухай хууль;
- Малын генетик нөөцийн тухай хууль;
- Тариалангийн тухай хууль;
- Усны тухай хууль;
- Ургамал хамгааллын тухай хууль;
- Таримал ургамлын үр сортын тухай хууль;
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль;
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль.

Улсын Их Хурлын тогтоол:

- УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”;
- УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”;
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
- УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”;
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөр;
- УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Ус” үндэсний хөтөлбөр;
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүд.

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр;
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр;
- Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр;
- Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоолоор баталсан “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр;
- Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр;
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”.

Стандартууд:

- MNS ISO 22000 : 2019 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрхлэгчид тавих шаардлага;
- MNS 6308 : 2012 Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ;
- MNS 6361 : 2012 Хүнс, малын тэжээл дэх микотоксины үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

- MNS 5868 : 2008 Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 4504 : 2008 Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS CAC 193 : 2007 Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт;
- MNS CAC MRL 2 : 2017 Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 5684 : 2006 Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNC CAC GL 19 : 2007 Хүнсний аюулгүй байдлын онцгой нөхцөл байдалд мэдээлэл солилцох зарчим ба арга зүйн заавар;
- MNC CAC GL 26 : 2006 Хүнсний импорт ба экспортын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх болон итгэмжлэх ерөнхий зарчим;
- MNC CAC GL 27 : 2007 Импортын болон экспортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтад оролцогч шинжилгээний лабораториудын чадавхын үнэлгээний зөвлөмж;
- MNS 6420 : 2013 Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мал, амьтны тэжээлд агуулагдах нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 6848 : 2020 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдэг;
- MNS ISO 22002-4: 2020 Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл.

Сайдын тушаал:

- Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" А/74 дүгээр тушаал;
- ХХААХҮС-ын 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-178 дугаар тушаалаар баталсан "Малын эмийн үлдэгдлийн хяналт"-ын үндэсний хөтөлбөр
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын Гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хаш-Эрдэнэ, аудитор Х.Энх-Амгалан, М.Баяртогтох, Ж.Мөнхбилгүүн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Аудитын явцад эрх бүхий этгээдийн шийдвэрээр багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

Аудит хийх хугацаа:

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2021 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулна.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гүйцэтгэх бөгөөд аудиторууд талбарын ажлын явцад аудитын дэд тайланг бичиж, нэгдсэн тайланг 11 дүгээр сарын 02-ны өдрөөс боловсруулж эхлэх ба үе шатны хяналтыг хөтөлбөрийн дагуу хийлгэн, Аудитын зөвлөлийн хурлаар 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, батлуулна.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд энэхүү төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, тайланг баталгаажуулан, холбогдох судалгаа, зөрчлийн жагсаалтын хамт Үндэсний аудитын газарт 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн дотор

5/11

ирүүлнэ. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд орон нутгийн онцлогт тохируулж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг дахин баталж болно.

Аудитын тайланг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Аудитын хөтөлбөр:

Асуудлын шинжилгээнд тусгагдсан асуудлаар аудитын багийн гишүүдийн гүйцэтгэх ажлыг хуваарилж, аудитын хөтөлбөрт тусгав. Аудитын багийн гишүүд талбарын ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана. (Хавсралт 4)

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч этгээдэд танилцуулахаас гадна хамаарал бүхий хэсэгтэй бусад шалгагдагч байгууллагад танилцах боломжийг олгоно. Шалгагдагч этгээдээс санал авч, нэгтгэл тайлангийн эцсийн хувилбарыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлнэ.

Аудитад шаардагдах нөөц:

Аудитад шаардагдах зардлын төсөв, түүний тооцоолол. Үүнд:

А. Хүний нөөц: $YAG - \text{аас } 4 \text{ хүн} \times 141 \text{ хүн/өдөр} = 564 \text{ хүн/өдөр}$
Аудитын гуравдугаар газрын захирал болон
аудитын менежерийн хяналт 15 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц: Нийт 111,494.1 мянган төгрөг. Үүнээс:
а/ Цалин

- Цалин $4 \text{ хүн} \times 68.6^1 \text{ мянган төгрөг} \times 141 \text{ өдөр} = 38,690.4 \text{ мянган төгрөг}$
- Цалин $2 \text{ хүн} \times 75.9^2 \text{ мянган төгрөг} \times 15 \text{ өдөр} = 2,277.3 \text{ мянган төгрөг}$

б/ Бичиг хэргийн зардал: 100.0 мянган төгрөг

в/ Томилолтын зардал: 10,426.4 мянган төгрөг

г/ Шинжээчийн зардал: 60,000.0 мянган төгрөг

д/ Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, зургийн аппарат, бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг хянаж, зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Я.САРАНСҮХ

Хянасан:

¹ Аудиторуудын цалинг үндсэн цалингаар тооцоолон 1 өдрийн цалинг дунджаар тооцоолов

² Газрын захирал, аудитын менежерийн цалинг үндсэн цалингаар тооцоолон 1 өдрийн цалинг дунджаар тооцоолов

811

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХБОЛД

Б.ДОЛГОРСҮРЭН

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Б.ХАШ-ЭРДЭНЭ

Х.ЭНХ-АМГАЛАН

М.БАЯРТОГТОХ

Ж.МӨНХБИЛГҮҮН

2021 оны 08 дугаар сарын ³¹ -ний өдөр